

БАТЛАВ:

САНХҮҮ ХАНГАЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА ДЭД
ХУРАНДАА

Я.ГАНТӨМӨР



БАТЛАВ:

"ТОРГОНЫ ЗАМ ХАНГАМЖ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Н.НАРАНТУЯА



ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2019 оны 06 дугаар
сарын 25 ны өдөр

дугаар:

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар /цаашид "Захиалагч" тал гэх/, нөгөө талаас "Торгоны зам хангамж" ХХК /цаашид "Нийлүүлэгч" гэх/ нь бүтээгдэхүүн захиалах, нийлүүлэх, хүлээн авах харилцааны үндсэн дээр харилцан тохиролцож байгуулав.

Гэрээний зорилго нь зоогийн газрын ширээ сандал, сандлын бүрээсийг /ХАВСРАЛТ-1/ 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс ажлын 15 хоногийн хугацаатайгаар захиалгын дагуу нийлүүлэхэд оршино.

НЭГ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 1.1 Гүйцэтгэгч нь захиалагч талын хүссэн бараа бүтээгдэхүүнийг имэйл болон захиалгат хуудасны дагуу гүйцэтгэн захиалгыг хүлээн авна.
- 1.2 Захиалагчийн хүссэн бараа бүтээгдэхүүнийг зарлагын баримтын дагуу хүлээлгэн өгч гарын үсэг зуруулна.
- 1.3 Захиалагч талын хүсэлтийн дагуух бараа бүтээгдэхүүнийг дур мэдэн өөрчлөх эрхгүй.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1 Захиалагч тал нь барааг хүлээн авахдаа тоо хэмжээ, болон чанарыг тухай бүрд нь шалгаж хүлээн авч гарын үсэг зурна.
- 2.2 Захиалагчнь гарын үсэг зурсан буюу нэгэнт хүлээн авсан барааныхаа дутагдал, гэмтэл, эвдрэлийг өөрсдөө бүрэн хариуцна.
- 2.3 Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас гүйцэтгэгч талд учруулсан хохирлыг бүрэн хариуцна.
- 2.4 Захиалагчнь гүйцэтгэгчийн учруулсан аливаа хохирлыг нэхэмжлэн авах эрхтэй.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Захиалагч тал нь захиалгын нийт үнийн дүн болох 9,331,400 төгрөгийн 70 хувь буюу 6,531,980 төгрөгийг гүйцэтгэгчийн "Хас банк"-ны 5002590107 тоот дансанд шилжүүлснээр захиалга баталгаажна. Бараа бэлэн болсон даруйд үлдэгдэл 30 хувь буюу 2,799,420 төгрөгийг гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.
- 3.2 Гүйцэтгэгч тал төлбөр хийгдсэн өдөр НӨАТын падааныг шивж оруулна.

ДӨРӨВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 4.1 Аль нэг тал гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол гэрээг цуцлах бөгөөд гарсан хохирлыг барагдуулна.